



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 12/20

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох,
тендер хүчингүй болгож, дахин зохион байгуулах тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.4, тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үнэлгээний хорооны хуралдааны 2026 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн 02 дугаар зөвлөмжийн дагуу ӨВАБОЭТ/20260102011/01/01 урилгын дугаартай хоол хүнсний материал нийлүүлэх тендерийн шалгаруулалтад "Хамгийн сайн" үнэлэгдсэн 3 дугаар багц гурил гурилан бүтээгдэхүүнийг 23,124,000 (хорин гурван сая нэг зуун хорин дөрвөн мянга) төгрөгөөр Эмтбулаг ХХК-иар, 4 дүгээр багц шош будааг 28,116,000 (хорин найман сая нэг зуун арван зургаан мянга) төгрөгөөр Эмтбулаг ХХК-иар, 6 дугаар багц хүнсний ногоог 63,459,600 (жаран гурван сая дөрвөн зуун тавин есөн мянга зургаан зуу) төгрөгөөр Эмтбулаг ХХК-иар, 7 дугаар багц хүнсний нарийн ногоог 10,368,000 (арван сая гурван зуун жаран найман мянга) төгрөгөөр Эмт булаг ХХК-иар, 8 дугаар багц жимс, жимсэн бүтээгдэхүүнийг 23,454,000 (хорин гурван сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга) төгрөгөөр Эмтбулаг ХХК-иар, 9 дүгээр багц хүнсний туслах бүтээгдэхүүнийг 60,282,600 (жаран сая хоёр зуун наян хоёр мянга зургаан зуу) төгрөгөөр Эмтбулаг ХХК-иар тус тус гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сургалт хөгжил, бодлого төлөвлөт, гүйцэтгэлийн албаны дарга (Д.Аззаяа) даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Ерөнхий санхүүч (Г.Ганчөдөр)-т зөвшөөрсүгэй.

4. Тендерт оролцогчийн тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртөг хэтэрсэн болон шаардлагад нийцсэн оролцогч оролцоогүй тендерийн 1 дүгээр багц сүү, сүүн бүтээгдэхүүн, 2 дугаар багц мах, махан бүтээгдэхүүн, 5 дугаар багц хуурай бүтээгдэхүүнийг тус тус хүчингүй болгосугай.

5. Дээрх хүчингүй болсон багцуудын тендер шалгаруулалтыг хуулийн дагуу дахин зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Д.Аззаяа)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Г.ДАШЖАНЦАН